



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДОА-2020/119/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Чойбалсан хот 2020 он	Дорнод аймаг дахь Төрийн газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn Аудитын менежер: В.Цэнгэлмаа Утас: 70584204 Цахим хаяг: Tsengelmaav@audit.gov.mn Аудитор: Ж.Баяртуул Утас: 70584207 Цахим хаяг: Bayartuulj @audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч



Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2020.02.11 № 33

танай -ны № -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн Сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын Олон Улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

110519513



Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.1. Оршил

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг эрхлэгч Д.Отгонбаяр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 20-ноос 2020 оны 02 дугаар сарын 05-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аудитор Ж.Баяртуул хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 2 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Төрийн аудитын байгууллагаас



санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Сургуулийн өмнөх насны хүүхдийн сургалт, төлөвшсөн иргэн болгож хүмүүжүүлж, эрүүл монгол иргэн болгон өсгөхөд”-д оршино.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Асoulus” программ хангамж ашигладаг байна.

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 281,501.0 мянган төгрөгөөс тооцон 5,630.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.



Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 7,492.4 мянган төгрөгөөр тооцсон болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэг нь 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 35,951.9 төгрөгөөр буюу 27.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт “үндсэн хөрөнгө”-ийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	29,315.4	31,693.4	2,378.0
Үндсэн хөрөнгө	910,040.6	945,992.5	35,951.9
Нийт хөрөнгө	939,356.0	977,721.0	38,364.9
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	38,580.0	38,580.0	-
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	939,356.0	977,721.0	38,364.9

Үндсэн хөрөнгийн жилийн эцсийн үлдэгдэл өссөн хөрөнгө оруулалт хийгдсэнээс шалтгаалжээ. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 58,869.3 мянган төгрөгийн гадна дулааны шугамын ажил хийгдэж, эцэг эхийн хандиваар 770,0 мянган төгрөгийн тавилга нэмэгдсэн байна. Хуримтлагдсан элэгдлийн дүн нь 23,687.4 мянган төгрөгөөр буурч нийт дүнгээрээ 35,951,9 мянган төгрөгөөр өссөн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Улсын төсөв	300,373.1	300,373.3	0.2	0
Орон нутгийн төсөв	14,234.5	12,247.1	1,987.1	99.4
Нэмэлт санхүүжилт	247.5	247.5	0	0
Нийт дүн	314,855.1	312,867.7	51987.3.3	99.4



Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан үндсэн үйл ажиллагаанд 314,607.6 мянган төгрөгийн төсөв батлагдсан нь урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 300,8373.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 14,234.5 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,620.2 мянган төгрөг буюу 99.4 хувьтай байна.

Нэмэлт төсөв: Туслах аж ахуйгаас 247.5 мянган төгрөгийн орлогыг авч бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 31 эрсдэлээс гүйцэтгэх үе шатанд 13 эрсдэл тодорхойлж нийт 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 25,096.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 албан шаардлага өгч ажиллаа.

Тайлант хугацаанд хийсэн нийт 25,096.6 мянган төгрөгийн худалдан авалтын Е баримтыг анхан шатны баримтад хавсаргаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 3.1.3 дахь заалтад “анхан шатны баримт гэж, төлбөр төлсөн баримт болон бусад нотолгоог”, 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна.”, 13.5 дахь хэсэгт “... цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна”, Төсвийн тухай хуулийн 41.2.3 дахь заалтад “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх заавар”-ын 6.5 дахь Монгол Улсын стандарт MNS 6529:2015 “татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан тусгай нууцлалын QR кодоор баталгаажсан анхан шатны цаасан баримтуудыг бүрдүүлж ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч Е баримтыг хавсаргах” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 146 мэдээллийг хугацаанд бүрэн байршуулсан байна.



2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Хэрлэн сумын 15 дугаар цэцэрлэгийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	29 315 451,40	31 728 489,40
35	БАРАА МАТЕРИАЛ	29 315 451,40	31 728 489,40
354	Хангамжийн материал	29 315 451,40	31 728 489,40
35410	Бичиг хэргийн материал	-	35 000,00
35470	Бусад хангамжийн материал	29 315 451,40	31 693 489,40
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	910 040 637,30	945 992 554,86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	910 040 637,30	945 992 554,86
392	Биет хөрөнгө	870 690 637,30	906 796 554,82
39201	Барилга, байгууламж, орон сууц	835 933 702,51	883 593 473,51
39202	Хуримтлагдсан элэгдэл	(14 639 443,65)	(29 806 321,89)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25 846 596,30	33 599 096,30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(4 881 780,72)	(8 980 738,68)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11 367 183,60	15 594 231,60
39208	Хуримтлагдсан элэгдэл	(2 059 658,57)	(3 929 864,09)
39214	Бусад үндсэн хөрөнгө	21 813 533,00	21 813 533,00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(2 689 495,17)	(5 086 854,93)
393	Биет бус хөрөнгө	39 350 000,00	39 196 000,04
39301	Програм хангамж	770 000,00	770 000,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	(153 999,96)
39303	Бусад биет бус хөрөнгө	38 580 000,00	38 580 000,00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	939 356 088,70	977 721 044,26
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	939 356 088,70	977 721 044,26
51	Засгийн газрын хувь оролцоо	939 356 088,70	977 721 044,26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	38 580 000,00	38 580 000,00
51101	Өмч: - төрийн	38 580 000,00	38 580 000,00
512	Хуримтлагдсан үр дүн	900 243 363,19	938 608 318,75
51210	Өмнөх үеийн үр дүн	899 407 931,27	900 243 363,19
51220	Тайлант үеийн үр дүн	835 431,92	38 364 955,56
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	532 725,51	532 725,51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	939 356 088,70	977 721 044,26



4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	281 501 025,00	374 619 419,00
12	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	18 275 325,00	59 764 319,00
120	Нийтлэг татварын бүс орлого	385 052,00	125 000,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	385 052,00	125 000,00
1200045	Үнэ төлбөргүй худээн авсан орлого	385 052,00	125 000,00
121	Хөрөнгийн орлого	17 890 273,00	59 639 319,00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө	17 890 273,00	59 639 319,00
	борлуулсны орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263 225 700,00	314 855 100,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	252 856 800,00	300 373 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	252 856 800,00	300 373 100,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10 368 900,00	247 500,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс		
	доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9 863 900,00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий	505 000,00	247 500,00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	14 234 500,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	-	14 234 500,00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	280 665 593,08	336 254 463,44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	280 665 593,08	336 254 463,44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	280 665 543,08	334 067 104,44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179 843 340,00	224 625 900,00
210101	Үндсэн цалин	150 035 958,00	202 492 122,00
210102	Нэмэгдэл	5 322 065,00	2 570 710,00
210104	Урамшуулал	12 968 165,00	19 563 068,00
210105	Гэрээт ажлын хөлс	11 517 152,00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 312 897,00	28 078 300,00
210201	Тэтгэврийн даатгал	14 108 224,00	19 093 300,00
210202	Тэтгэмжийн даатгал	1 415 955,00	2 246 200,00
210203	ҮОМЦӨ-ний даатгал	1 711 459,00	1 797 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	617 598,00	449 200,00
210205	Эрүүд мэндийн даатгал	3 459 661,00	4 492 600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 750 800,00	10 947 192,00
210301	Гэрэл, цахилгаан	4 976 767,00	4 515 452,00
210302	Түлш, халаалт	2 339 260,00	2 055 900,00
210303	Цэвэр, бохир ус	4 434 773,00	4 375 840,00
2104	Хангамж, бараа материалын зардал	3 609 850,00	3 685 811,00
210401	Бичиг хэрэг	378 400,00	506 660,00
210402	Тээвэр, шатахуун	2 193 950,00	1 598 851,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495 000,00	495 000,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	350 350,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	542 500,00	734 950,00
2105	Нормативт зардал	40 130 650,00	41 397 850,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100 000,00	100 000,00
210502	Хоол, хүнс	40 030 650,00	41 297 850,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	159 650,00
210604	Урсгал засвар	-	159 650,00
2107	Томилолт, зочны зардал	100 000,00	120 000,00
210702	Дотоод албан томилолт	100 000,00	120 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	380 000,00	590 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний	200 000,00	410 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23 538 006,08	24 462 401,44
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	300 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	475 000,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23 038 006,08	23 687 401,44
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,00	2 187 359,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	200 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,00	1 987 359,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,00	1 987 359,00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	835 431,92	38 364 955,56
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	835 431,92	38 364 955,56



4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	263 225 700,00	314 855 100,00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	263 225 700,00	314 855 100,00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	252 856 800,00	300 373 100,00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	252 856 800,00	300 373 100,00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10 368 900,00	247 500,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан	9 863 900,00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	505 000,00	247 500,00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	14 234 500,00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	14 234 500,00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	263 225 700,00	314 855 100,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	263 225 700,00	314 855 100,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	263 225 650,00	312 667 741,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180 564 432,00	224 625 900,00
210101	Үндсэн цалин	148 168 686,00	202 492 122,00
210102	Нэмэгдэл	6 081 156,00	2 570 710,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт		
210104	Урамшуулал	12 968 165,00	19 563 068,00
210105	Гэрээт ажлын хөлс	13 346 425,00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21 773 768,00	28 078 300,00
210201	Тэтгэврийн даатгал	14 810 368,00	19 093 300,00
210202	Тэтгэмжийн даатгал	1 473 700,00	2 246 200,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 659 800,00	1 797 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	348 200,00	449 200,00
210205	Эрүүл мэндийн даатгал	3 481 700,00	4 492 600,00
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/		
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11 750 800,00	10 947 192,00
210301	Гэрэл, цахилгаан	4 976 767,00	4 515 452,00
210302	Түлш, халаалт	2 339 260,00	2 055 900,00
210303	Цэвэр, бохир ус	4 434 773,00	4 375 840,00
2104	Хангамж, бараа материалын зардал	7 826 000,00	4 208 499,00
210401	Бичиг хэрэг	422 400,00	541 660,00
210402	Тээвэр, шатахуун	2 193 950,00	1 598 851,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495 000,00	495 000,00
210404	Ном, хэвлэл	89 000,00	171 488,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал,	-	350 350,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4 625 650,00	1 051 150,00
2105	Нормативт зардал	40 130 650,00	41 997 850,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100 000,00	100 000,00
210502	Хоол, хүнс	40 030 650,00	41 297 850,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1 300 000,00
210604	Урсгал засвар	-	1 300 000,00
2107	Томилолт, зочны зардал	100 000,00	120 000,00
210702	Дотоод албан томилолт	100 000,00	120 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	380 000,00	590 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	200 000,00	410 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	700 000,00	800 000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	500 000,00	300 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	200 000,00	500 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	50,00	2 187 359,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	200 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	200 000,00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	50,00	1 987 359,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	50,00	1 987 359,00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	38 580 000,00	532 725,51	900 243 363,19	0,00	939 356 088,70
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын					0,00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38 580 000,00	532 725,51	900 243 363,19	0,00	939 356 088,70
C08	2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38 580 000,00	532 725,51	900 243 363,19	0,00	939 356 088,70
D01	2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	38 580 000,00	532 725,51	900 243 363,19	0,00	939 356 088,70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын	0,00	0,00	0,00	0,00	0,00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38 580 000,00	532 725,51	900 243 363,19	0,00	939 356 088,70
D08	Тайлант үеийн үр дүн	0,00	0,00	38 364 955,56	0,00	38 364 955,56
D09	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	38 580 000,00	532 725,51	938 608 318,75	0,00	977 721 044,26



4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	314 607 600,00	312 620 241,00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	314 607 600,00	312 620 241,00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	314 407 600,00	312 420 241,00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	224 625 900,00	224 625 900,00
210101	Үндсэн цалин	201 531 700,00	202 492 122,00
210102	Нэмэгдэл	2 931 300,00	2 570 710,00
210104	Урамшуулал	20 162 900,00	19 563 068,00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шим	28 078 300,00	28 078 300,00
210201	Тэтгэврийн даатгал	19 093 300,00	19 093 300,00
210202	Тэтгэмжийн даатгал	2 246 200,00	2 246 200,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1 797 000,00	1 797 000,00
210204	Ажилгүйдлийн даатгал	449 200,00	449 200,00
210205	Эрүүл мэндийн даатгал	4 492 600,00	4 492 600,00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	12 934 500,00	10 947 192,00
210301	Гэрэл, цахилгаан	5 368 500,00	4 515 452,00
210302	Түлш, халаалт	2 464 000,00	2 055 900,00
210303	Цэвэр, бохир ус	5 102 000,00	4 375 840,00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	3 961 000,00	3 960 999,00
210401	Бичиг хэрэг	250 000,00	294 160,00
210402	Тээвэр, шатахуун	2 115 100,00	1 598 851,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	495 000,00	495 000,00
210404	Ном, хэвлэл	150 000,00	171 488,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн уст	450 900,00	350 350,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500 000,00	1 051 150,00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
2105	Нормативт зардал	41 997 900,00	41 997 850,00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100 000,00	100 000,00
210502	Хоол, хүнс	41 297 900,00	41 297 850,00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	600 000,00	600 000,00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1 300 000,00	1 300 000,00
210604	Урсгал засвар	1 300 000,00	1 300 000,00
2107	Томилолт, зочны зардал	120 000,00	120 000,00
210702	Дотоод албан томилолт	120 000,00	120 000,00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төл	590 000,00	590 000,00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үй	410 000,00	410 000,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180 000,00	180 000,00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	800 000,00	800 000,00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300 000,00	300 000,00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500 000,00	500 000,00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	200 000,00	200 000,00
2132	Бусад урсгал шилжүүлэг	200 000,00	200 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	200 000,00	200 000,00

